

Судалгааны Тойм

№19 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ, ЯЛ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛ ОРОН НУТАГТ

ТОВЧ ТАЙЛБАР

Хүн гэр бүлдээ аюулгүй, амар тайван байх нь хамгийн чухал хэрэгцээний нэг билээ. Үүнийг алдагдуулж буй гол хүчин зүйл бол гэр бүлийн хүчирхийлэл юм. Гэвч жилээс жилд гэр бүлийн хүчирхийллийн тоон үзүүлэлт өссөөр байна. Тиймээс шинэ Эрүүгийн хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг гэмт хэрэгт тооцож хуульчилсан билээ. Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар хийсэн цөөнгүй судалгаа байдаг ч орон нутгийн түвшинд, тэр дундаа, Ховд аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл,

гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж буй ял шийтгэл, үр нөлөөний талаар хийсэн судалгаа байхгүй байна. Иймд уг хэрэгт оногдуулж буй ял, шийтгэлийн үр нөлөөг орон нутгийн түвшинд судлах замаар анхан шатны нэгжид хуулийн хэрэгжилт хэр байгаа болон авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний үр өгөөжийг үнэлж дүгнэх зорилгоор уг судалгааг хийсэн. Энэхүү тоймоор тус судалгааны гол үр дүн, санал, зөвлөмжийг уншигчдад хүргэхийг зорив. Судалгааг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас татаж үзнэ үү.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, ял шийтгэл оногдуулж буй байдлыг судлахдаа баримт бичгийн судалгааг бодит нөхцөл байдлын судалгаатай хослуулан хийлээ. Тухайлбал, Ховд аймгийн цагдаагийн газарт бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн нийт 68 хэрэгт дүн шинжилгээ хийж, баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн хүмүүстэй фокус бүлгийн уулзалт, хэлэлцүүлэг хийж үр дүнг тандлаа. Мөн Ховд аймгийн ГБХЗХГ-т бүртгэгдсэн кэйс болон бусад бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж холбогдох бусад

төрийн ажилтан, албан хаагчдаас асуулга авав. Түүнчлэн үндэсний хэмжээнд цацагдаж байгаа телевизийн томоохон таван суваг, орон нутгийн дөрвөн телевизийн контентод ажиглалт, дүгнэлт хийж, анкет асуулгын аргаар нийт 100 хүүхдээс судалгаа авлаа. Судалгаанд аймгийн төвийн Цаст Алтай цогцолбор сургууль, гэр хорооллын хэсэгт байх 7-р сургууль болон тус сургуулийн дотуур байрны хүүхдүүдийг хамруулав. Насанд хүрэгчдийн судалгаанд 100 эмэгтэй, 50 эрэгтэй, мөн гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэж баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн 50 эрэгтэйг хамрууллаа.

СУДАЛГААНЫ ДҮН

Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хүүхэд хамгааллын тухай, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль, бусад холбогдох дүрэм журмын хүрээнд зохицуулсан байдаг. Ховд аймгийн хувьд “Гэр бүлийн хөгжил хамгааллыг дэмжих дэд хөтөлбөр”, “Жендерийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”, “Тайван амгалан Ховдууд хөтөлбөр”, “Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичиг баталж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна. Эдгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг шинжлэхэд хийх ажлаа аль болох бодитой, тодорхой, хүрч болохуйц, хэрэгжих боломжтой, хэмжигдэхүйц байдлаар төлөвлөөгүйгээс үүдэн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзлээ. Мөн төрийн албан хаагчдын ажлын ачаалал, ажил үүргийн хуваарийг нягталж үзэх нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй юм. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудын ихэнх нь төрийн албан хаагч, эцэг эхийн зөвлөл гэх мэт нийгмийн идэвхтэй хэсэгт чиглэсэн байгаагаас үзэхэд зорилтот бүлэгтээ хүрч чадаагүй гэж үзэж болохоор байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүмүүсийн статистик мэдээллээс харахад ихэнх нь бүрэн дунд боловсролтой, ажилгүй иргэд байдаг. Мөн төрөөс хэрэгжүүлж буй аливаа ажил, үйлчилгээ уламжлалт арга барилаар буюу танхимын сургалт, хурал, семинар, олон нийтийг хамарсан баяр ёслолд илүүтэй чиглэжээ. Энэ нь орчин цагийн хүмүүсийн эрэлт хэрэгцээ, амьдралын хэмнэлд төдийлөн хүртээмжтэй байж чадахгүй байна.

2020 оны эхний 8 сарын байдлаар Ховд аймгийн Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 118 гомдол мэдээлэл хүлээн авч,

үүнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 17, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 1, зөрчлийн хэрэг 100 тус тус бүртгэгджээ. Гэр бүлийн хүчирхийллийн гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1.3 дахин өсжээ. Харин гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.4 дахин өссөн үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийллийн 70 гаруй хувь нь гэр бүлийн хүрээнд архидан согтуурсан үед үйлдэгдэж байгаа бөгөөд үүнд хамаарах зарим гэмт хэрэг, зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 буюу “бусдын амгалан тайван байдал алдагдуулсан”, 15 дугаар зүйлийн 15.9.1 буюу “худал дуудлага мэдээлэл өгсөн” гэх заалтаар шийдвэрлэж байгааг тухайн салбарын мэргэжилтнүүдийн мэдээлэл, хохирогч эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс олж харлаа.

Зөрчлийн тухай хуулийн шийтгэл нь хүчирхийлэл үйлдэгчдэд нөлөөлж чадахгүй, үр дүн муутай буюу гэр бүлд нь эргээд сэтгэл санаа, эдийн засгийн дарамт учруулж байгаа бөгөөд өөр төрлийн шийтгэвэр, арга хэмжээ үгүйлэгдэж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж байгаа “баривчлах” шийтгэл үр дүнгүй байдаг учир тухайн хохирогч мэдүүлгээсээ буцах, торгуулийн дүн бага зөрчлөөр шийдүүлэх, улмаар цагдаагийн байгууллагад гомдол мэдүүлэхээ болих шийдэлд хүрч байгаа нь хүчирхийллийг даамжруулах эрсдэл дагуулж байна. Тухайн гэр бүлийн зөрчил Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан нөхцөлөөр шийтгүүлэхээргүй буюу эрт шатандаа байх тохиолдолд хөнгөн хариуцлага оногдуулах зохицуулалтыг нэмж тусгах тухайлбал, зан үйлд нөлөөлөх сургалтад суулгахыг даалгах, сануулах гэх мэт байж болох юм.

Ховд аймгийн Шүүхийн тамгын газрын мэдээнээс үзэхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой Эрүүгийн хуулиар шийдвэрлэж байгаа хэргийн ихэнх нь Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.2, 11.7 дахь заалтын хүрээнд шийдвэрлэгджээ. Ийнхүү дийлэнх хэргийн шийдвэрлэлтээс харахад хүчирхийлэл үйлдэгчдэд ихэвчлэн мөнгөн торгууль ногдуулж байна. Энэ нь хүчирхийлэл үйлдэгч гэм буруугаа ухамсарлаж, зан үйлээ өөрчлөхөд нөлөөлөхүйц шийдэл биш юм. Мөн Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийн зарим хэлбэр болох "сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл" гэсэн хоёр төрлийн хүчирхийллийг хэрхэн яаж шийдвэрлэх, түүнд ямар арга хэмжээ авах тухай тодорхой тусгаагүй байгааг анхаарах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, дээрх хоёр төрлийн хүчирхийллийг Эрүүгийн хуульд бусад хоёр төрлөөс нь ялгаж оруулаагүй. Гэтэл гэр бүлийн хүчирхийллийн далд хэлбэр их байгаа гэх судалгааны дүнгээс харахад ихэнх нь энэ хоёр төрлийн хүчирхийлэл байдаг.

Цагдаагийн газарт ирж байгаа бусдын амгалан тайван байдал алдагдуулсан гэх дуудлага мэдээллийг ангилан үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл байж болохуйц шинж тэмдэгтэй дуудлага, гомдол бүртгэгдсэн байх нь бий. Тиймээс Цагдаагийн газар ирж байгаа гэр бүлийн хүрээнд архидан согтуурсан, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан гэх гомдол мэдээллийг шинжлэн үзэж, гэр бүлийн хүчирхийллийн шинж тэмдэг байгаа эсэхийг харгалзан, давхар хөршийн хяналтын хүрээнд мэдээлэл цуглуулах замаар дээр дурдсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэлбэрийг ашигладаг байвал тухайн хохирогч, холбогдогчдод илүү үр өгөөжтэй. Харин энэ төрлийн зөрчлийг "Зөрчлийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 5.5.1-ийн дагуу нэг зуун нэгж буюу 100,000 төгрөгөөр торгож байна. Үүний улмаас аль болох цагдаад дуудлага өгөхгүйг

хичээж, хүчирхийллийг тэвчин өнгөрүүлж байгаа нь асуудлыг улам даамжруулж байгаа болохыг судалгаанд оролцогчид илэрхийлж байсан.

Зан үйлд нөлөөлөх сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх ажил зохион байгуулахгүй бол өнөөгийн хэрэгжүүлж буй арга зам үр дүнгүй байна. Тухайлбал, Цагдаагийн газрын Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын сэдэв, хөтөлбөрөөс харахад тухайн хүмүүст ихэвчлэн хууль, дүрмийн талаарх мэдлэг, архи тамхины хэрэглээ буюу хорт зуршлын сөрөг үр дагаврын талаар сургалт хийдэг нь төдийлөн үр дүнтэй биш байгаа юм. Энэ нь цагдаагийн байгууллагын ажилтан чиг үүргийнхээ хувьд өөр олон төрлийн ажил, үүрэгтэй байдгаас үүдэн зан үйлд нөлөөлөх, сэтгэл зүйн сургалт руу төвлөрч, өөрсдийгөө мэргэшүүлэх боломж хомс байдаг нь үр дүнгүй байгаагийн шалтгаан гэж харж байна.

Асуулгад оролцсон гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зүгээс "Гэр бүлийн хүчирхийллийн цаад учир, холбогдлыг орхигдуулж зөвхөн эрчүүдэд бурууг өгөх хандлага их байдаг. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн гэр бүлийн гишүүд зан үйлд нөлөөлөх сургалтад хамтдаа хамрагддаг байх нь одоо явж байгаа хүчирхийлэгчийг албадан сургадаг сургалтаас илүү ач холбогдолтой" болохыг онцолсон. Тиймээс эхнэр, нөхөр, хүүхэд зэрэг гэр бүлийн бүх гишүүний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон сэтгэл зүйн болон зан төлөвийн сургалт, нөлөөллийн ажил зайлшгүй шаардлагатай байна. Үүний тулд сургалт, нөлөөллийн ажил явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд ганцаарчилсан зөвлөгөө авах боломжоор хангах, багийн нийгмийн ажилтнуудыг иргэдэд илүү ойр ажиллах боломжийг бүрдүүлэх, мэргэшүүлэх хэрэгтэй юм.

Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд хэвлэл мэдээллийн

хэрэгслийн гүйцэтгэх үүрэг өндөр билээ. Тиймээс судалгааны хүрээнд үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн контентод дүн шинжилгээ хийж үзэхэд Монголын үндэсний олон нийтийн телевиз өдрийн эфирийн цагийн 7.6 хувь, Монгол HD ТВ 3.6 хувь, TV-9 телевиз 1.4 хувь, UBS-1 телевиз 1.4 хувь, ETV телевиз 1.4 хувь, MN25 телевиз 1.1 хувь, NTV 0.96 хувь, TV-5 0.96 хувь, Боловсрол телевиз 0.55 хувь, C1 телевиз 0.51 хувийг гэр бүлийн

хөгжил, төлөвшил, дадал хэвшилд үзүүлж буй эерэг нөлөөлөл бүхий нэвтрүүлэгт зориулжээ. Харин орон нутгийн томоохон телевизүүд болох Ховд телевиз, Олон ястны телевизээр зорилтот нэвтрүүлгийн цаг байхгүй байв. Энэ нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгэм рүү хандсан нэвтрүүлэг хийхгүй, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэхгүй байгааг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

- Төрөөс хэрэгжүүлж буй ажлын цар хүрээг өргөтгөж зорилтот бүлэгт хүрч ажиллах.
- Прокурорын байгууллагын хяналтыг сайжруулах буюу шийдвэрлэгдэж буй гэмт хэрэг, зөрчилд оногдуулж буй ял шийтгэлийн хэрэгжилтийг хангахад анхаарах.
- Зан үйлд нөлөөлөх сургалтыг зөвхөн хүчирхийлэл үйлдэгч буюу холбогдогчдод хийх бус хохирогч, холбоо хамаарал бүхий гэр бүлийн бусад гишүүнд давхар өгч, сэтгэл зүйд нь нөлөөлөх арга ажиллагааг үр дүнтэй хийж хэвшүүлэх.
- Хуулийг ялгамжтай байдлаар ашиглаж гэр бүлийн хүчирхийллийг даамжруулж буй нөхцөл байдлыг анхаарч үзэх.
- Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын шалгуур үзүүлэлтийг хангуулахдаа хэргийг нуун далдлах байдал байгаа эсэхэд анхаарах. Урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийг илрүүлэх, тохирсон хариу арга хэмжээ авч, эрсдэлээс урьдчилан сэргийлж буй байдлыг онцолж үзэх, ажилтан алба хаагчдын хандлага ёс суртахуун, жендерийн мэдрэмжтэй байдлыг дээшлүүлэхэд түлхүү анхаарах.
- Гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж буй ял, шийтгэл түүний гүйцэтгэлийг хэрэгжүүлж буй цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудын хандлага, ур чадварыг нэмэгдүүлж, бусад нөөцөөр хангах.

СУДЛААЧИД:

Ж.САРУУЛ, “Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ-ын гүйцэтгэх захирал, ХБУ-ны магистр

Л.ОЮУНЦЭЦЭГ, Хууль зүйн туслалцааны төвийн “Ховд аймаг дахь салбар”-ын Улсын өмгөөлөгч

Ж.ЦЭЦЭГМАА, “Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ-ын судалгаа, шинжилгээний асуудал хариуцсан ажилтан

СУДАЛГААНЫ ТОЙМЫГ БОЛОВСРУУЛСАН:

Ж.САРУУЛ, “Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ-ын гүйцэтгэх захирал, ХБУ-ны магистр

САНАЛ, ШҮҮМЖ ӨГСӨН:

Б.ХИШИГСАЙХАН, ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер

